

2008.04.18

Дугаар 88

“Хөвсгөл гео эрдэнэ ББСБ” ХХК-ийн банк бус
санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийн гэрчилгээг шинэчлэн олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгохтой холбоотой баримт бичгийг бүрдүүлэн ирүүлсэн “Хөвсгөл гео эрдэнэ ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Хөвсгөл гео эрдэнэ ББСБ” ХХК /Д.Алтанцэцэг/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, шийдвэрийг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ